

## Төслийн нэр: Эцэг эхийн явуулын зөвлөх баг

### Хэсэг I: Төсөл санаачлагчийн мэдээлэл

Аймаг/ хот: Булган
Сум /дүүрэг: Орхон
Сургууль, СЭЭБХ-ны хаяг: Булган аймгийн Орхон сумын сургууль
СЭЭБХ-ны зохицуулагчийн овог, нэр: Т.Мөнгөн

### Хэсэг IIa. Нөхцөл байдлын шинжилгээ

Дотоод хүчин зүйлс	
<b>Давуу тал</b> 1. СЭЭБХ ажиллаад 2 жил болж байна. 2. Сумын иргэд, сургуулийн багш нар СЭЭБХ-ны талаар ойлголттой. 3. Сумын Засаг дарга, ажлын алба нь СЭЭБХ-ны талаар эерэг ойлголттой. Хамтарч ажилладаг. 4. СЭЭБХ-ны гишүүд нь үйл ажиллагаандаа идэвхтэй оролцдог.	<b>Сул тал</b> 1. Сүүлийн жил гаруй хугацаанд гишүүнчлэлээ нэмээгүй. 2. Гишүүд багаар ажиллах чадвар сул 3. Иргэний нийгэм, хүүхдийн эрхийн талаарх ойлголт, мэдлэг дутмаг 4. СЭЭБХ-ны удирдлага шинээр солигдсон. 5. Санхүүгийн тайлан гаргах, төсөл бичих чадвар байхгүй. 6. Мэдээлэл харилцааны чадвараа хөгжүүлэх шаардлагатай. 7. Эцэг эхчүүдийн оролцоо сул 8. Эцэг эхчүүд ном уншдаггүй.
Гадаад хүчин зүйлс	
<b>Боломж</b> 1. Багаар ажиллах чадвар сайжирна. 2. Иргэний нийгмийн тухай ойлголттой болж, байгууллагын хэмжээнд ажилладаг болно. 3. Шинээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх боломжтой болно. 4. СЭЭБХ-гоо илүү өргөн хүрээнд таниуулах, гишүүнчлэлээ хөгжүүлэх, тэлэх боломжтой болно.	<b>Эрсдэл</b> 1. Гишүүдийн оролцоо сул байдлаас болоод олон эцэг эхэд хүрч чадахгүй байж магадгүй. 2. Ном хөтөлбөрт цөөхөн эцэг эх хамрагдаж магадгүй. Мал төллөх, ногоо хураах цагаар эцэг эхчүүд оролцдоггүй.

### Хэсэг IIб. Төслийн зорилго, хамрах хүрээ

Зорилго	Эцэг эхийн зөвлөх баг байгуулан үйл ажиллагааг нь тогмолжуулж, эцэг эхийн оролцооны шинэ туршлагыг бий болгоно.
Хамрагдах хүний тоо	СЭЭБХ-ны гишүүн-45, багш-14, 1-5-р ангийн суралцагч-102, эцэг эх-100

### Хэсэг III. Төслийг хэрэгжүүлэх зохион байгуулалт ба ажлын төлөвлөгөө

№	Үйл ажиллагаа	Хариуцах эзэн	Хугацаа	Хүрэх үр дүн
1.	Төслийн нээлтийн үйл ажиллагаа	Сургуулийн удирдлага, СЭЭБХ-ны УЗ	2019.6-р сар	Төслийн хүрээнд зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг танилцуулна. СЭЭБХ-ны үйл ажиллагаа, ач холбогдлыг танилцуулна.
2.	Сургуулийн захиргаа, СЭЭБХ, зөвлөх багийн гишүүд гурвалсан	СЭЭБХ, Сургалтын менежер	2019 оны 9-сард	Сургуулийн захиргаатай хамтран зөвлөх багийн зорилго, үйл ажиллагааг төлөвлөж тохиролцоно. Тус бүр 4-5 хүний

	гэрээ байгуулж ойлголтоо нэгтгэнэ.			бүрэлдэхүүнтэй 2 зөвлөх багийг эцэг эхийн сайн дурын үндсэн дээр сонгож, багууд ажлаа төлөвлөнө. Зөвлөгөө авах малчин өрхийн судалгаа, ажлын хуваарь гаргах
3.	Эцэг эхийн үүрэг оролцооны талаар судалгаа авах  Хүмүүжлийн эерэг хандлагын тухай мэдээлэл түгээх	СЭЭБХ, Сургалтын менежер	2019 оны 9-р сар  9-р сараас тогтмол	Сумын төвд амьдардаг сурагчийн гэрээр айлчилж, бүх баг мэдээлэл зөвлөгөө өгсөн байна. Судалгаанд үндэслэн эцэг эхийн тодорхойлж, эцэг эхийг үүрэгжүүлнэ.
4.	Малчин өрхийн сурагчдын гэрээр улиралд нэг удаа айлчилна. <ul style="list-style-type: none"> <li>• Эцэг эхээс санал хүсэлт авна.</li> <li>• Сумын эцэг эхчүүд хамтран хүмүүжлийн эерэг хандлага сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулна.</li> <li>• Сурагчдын гэр бүлийн байдлын талаарх мэдээллийг сургуулийн захиргаанд гаргаж өгөх</li> </ul>	СЭЭБХ, Сургалтын менежер	2019 оны 9-р сараас тогтмол хуваарийн дагуу	Энэ хугацаанд дотуур байранд амьдардаг сурагчдын гэрээр айлчилж, мэдээлэл зөвлөгөө өгсөн байна.  Эцэг эх бүрийн хүмүүжлийн эерэг аргаас цуглуулж, хүмүүжлийн эерэг аргын цомог бэлтгэн сургуулийн захиргаагаар хянуулж, бүх эцэг эхэд түгээх аяныг өрнүүлнэ.
5.	Багуудын үйл ажиллагааны тайланг хэлэлцэх зорилготой уулзалт зохион байгуулах, сурвалжлах баг гаргах, багт зориулж сургалт зохион байгуулна.	СЭЭБХ, Аймгийн Хэвлэл мэдээллийн байгууллагаас дэмжлэг авна.	2019.10-р сард	<ul style="list-style-type: none"> <li>• Багууд үйл ажиллагаагаа сургуульд тайлагнах, үйл ажиллагаа бүрийг түгээх, сурталчлах “Эцэг эхийн сурвалжлах баг” гаргана. Бичих сонирхолтой эцэг эхийг сайн дурын үндсэн дээр энэ багт шалгаруулж авна.</li> <li>• Сурвалжлах багийн бүтээлийг <a href="http://Sainsurguuli.mn">Sainsurguuli.mn</a> сайт болон Сайн сургуулиас сайхан амьдрал эхэлнэ фэйсбүүк хуудсанд байршуулж, орон даяар түгээнэ. Мөн аймгийн ХМХ-ээр түгээнэ.</li> <li>• Эцэг эхчүүдэд тараах материал байдлаар түгээнэ.</li> </ul>

				Сургалтыг аймгийн хэвлэл мэдээллийн байгууллагаас арга зүйн дэмжлэг авч зохион байгуулна.
6.	Эцэг эх орон нутгийн хамтын ажиллагаа сургалт, хэлэлцүүлэг	СЭЭБҮНХ-ноос дэмжлэг авна.	2019.9-р сарын 24-27	Аймаг, сумын удирдлагуудтай хэрхэн хамтарч ажиллах тухай арга зүйн сургалтанд хамрагдаж, аймаг, сумын удирдлагуудтай хэлэлцүүлэг өрнүүлнэ. Хэлэлцүүлгийн үр дүнд хамтран ажиллах боломжуудыг ярилцаж, тохирно.
7.	Хүүхдийн эрх, хамгаалал, хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудаас туршлага судлах	Хүүхдийг ивээх сангийн “Хүүхэд хамгааллын арга зүйн төв”, Чингэлтэй дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн төв, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, “Хүүхэд, өсвөр үеийг ивээх” төв	2019.10-р сар	СЭЭБХ-ны Зохицуулагч, Удирдах зөвлөлийн гишүүд болон СЭЭБХ-ны үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог төрийн албан хаагч эцэг эхчүүдийн төлөөллийг энэ туршлага судлах аялалд хамруулна. УБ хотод үйл ажиллагаа явуулж буй төрийн болон ТББ, олон улсын байгууллагын туршлагаас судлах, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх зорилготой СЭЭБХ-ны алдаа оноог олж харах, цаашид үйл ажиллагаандаа санаа авч хэрэгжүүлнэ. Эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх тухай олон улсын төсөл, хөтөлбөртэй танилцах, санаа авах.
8.	Туршлага судлах хөтөлбөрт оролцогчид төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх	СЭЭБХ-ны төлөөллүүд	2019.10-р сар	Сургалт болон туршлага судлах хөтөлбөрийн хүрээнд сурсан зүйлээ өөрийн орон нутаг, эцэг эхчүүдэд хэрхэн түгээх, СЭЭБХ цаашид хэрхэн ажиллах талаар урт хугацааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ.
9.	Судалсан мэдлэг, ойлголт, туршлагаа хуваалцах уулзалт зохион байгуулах	СЭЭБХ-ны төлөөллүүд	2019.10-р сар	СЭЭБХ-ны гишүүдийн чадавх сайжирч, бусад эцэг эхийн оролцоо нэмэгдэнэ.
10.	Сурвалжлах багийн бүтээлийг эцэг эхчүүдэд түгээх  “СЭЭБХ-ны сонин”	СЭЭБХ, Сурвалжлах баг	2019 оны 10-р сараас	СЭЭБХ-ны сонин түгээх байдлаар сурвалжлах багийн бүтээлийг сумын иргэд, эцэг эхчүүдэд түгээнэ. Сонинг сар тутам эрхлэн гаргаж, түгээнэ. Нийт 9 дугаарыг төслийн хугацаанд гаргасан байна.
11.	Зөвлөх багийн гишүүн эцэг эх, бусад эцэг	СЭЭБХ, Сургалтын менежер	2019 оын 10-р сараас хуваарийн	Хүмүүжлийн эерэг арга, хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн чиглэлээр тогтмол ярилцдаг

	эхчүүдэд зориулсан асуултын хариултын цагтай болох		дагуу тогтмол	болно.
12.	Төслийн хаалт	СЭЭБХ	2020.4-р сарын сүүлийн 7 хоногт	Төслийн хугацаанд хийсэн үйл ажиллагааг тайлагнах, цаашид Хүүхэд-гэр бүл хөгжлийн өргөөг идэвхтэй, үр дүнтэй ажиллуулах төлөвлөлтөд санал, хүсэлт авна.

#### Хэсэг IV Зардлын задаргаа

Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ, төг	Нийт үнэ, төг	Хүрэх үр дүн
Төслийн нээлт, хаалтын үйл ажиллагаа <ul style="list-style-type: none"> <li>Баннер</li> <li>Станд</li> <li>Цайны материал</li> </ul>	удаа	2	100 000	200 000₮	Аймгийн удирдлагууд, эцэг эх, багш нарыг нээлтийн үйл ажиллагаанд урьж, СЭЭБХ-ны үйл ажиллагаа ач холбогдлыг танилцуулахаас гадна төслийн хүрээнд зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг танилцуулна.
<ul style="list-style-type: none"> <li>Өнгөт принтер</li> <li>Ламинатор</li> <li>Дуу хураагуур</li> </ul>	Ш	1	500 000₮	500 000₮	Төслийн хүрээнд шаардлагатай мэдээллийг хэвлэх, хувилах зэргээр ашиглана.
	Ш	1	120 000₮	120 000₮	
	Ш	1	120 000₮	120 000₮	
Сурвалжлах багт зориулсан сургалт	Удаа	1	150 000₮	150 000₮	Сургалтын хоол болон сургагч багшийн урамшуулал багтсан болно.
Эцэг эх, орон нутгийн хамтын ажиллагаа сургалт	Удаа	1	100 000₮	100 000₮	Сургалтын хоол болон сургагч багшийн урамшуулал багтсан болно.
Эцэг эх, орон нутгийн хамтын ажиллагаа хэлэлцүүлэг	Удаа	2	50 000₮	100 000₮	Сумын түвшинд эцэг эх, сумын удирдлагууд хамтран ажиллах шийдлээ тодорхойлно.
Туршлага судлах хөтөлбөрийн зардал	Удаа	1		945 000₮	УБ хотод байрлах, унаа болон бусад зардал  Унааны зардал  Томилолтын зардал
Туршлага судлах хөтөлбөрийн унааны зардал	2 талд	5	50 000₮	250 000₮	
Туршлага судлах хөтөлбөрийн томилолтын зардал	хоног	4	30 000-нэг хүнд х 5 хүн	600 000₮	
СЭЭБХ-ны гишүүд өөрийн орон нутгийн эцэг эхчүүдэд сургалт зохион байгуулна.	удаа	2	50 000₮	100 000₮	Сургалтад хамрагдсан эцэг эхчүүд СЭЭБХ-ны талаар эерэг ойлголттой болоод зогсохгүй, хүний эрх, хүүхдийн эрхийн тухай мэдлэгтэй болж СЭЭБХ-той хамтран ажилладаг болно.
Асуулт хариултын цаг	Удаа	10	20 000₮	200 000₮	Цайны материал авна.

Зөвлөх багийн үйл ажиллагаа	Ш	2	250 000₮	500 000₮	Багуудын үйл ажиллагаанд зориулна.
Бичиг хэрэг	удаа	4	150 000₮	600 000₮	Бичгийн цаас, принтерийн хор авна.
Харилцаа холбооны зардал				100 000₮	Төсөл хэрэгжүүлж байгаа багийн гишүүдийн харилцаа холбоо
Гэрээр айлчлах хөтөлбөрийн шатахууны зардал	багт	4	100 000₮	400 000₮	Сумын төв, малчдын гэрээр айлчилна.
Хүмүүжлийн эерэг аргын цомог гаргах, хэвлүүлэх				200 000₮	Эцэг эх бүрийн хүмүүжлийн эерэг аргаас цуглуулж, хүмүүжлийн эерэг аргын цомог бэлтгэн сургуулийн захиргаагаар хянуулж, бүх эцэг эхэд түгээх аяныг өрнүүлнэ.
Төслийн хаалтын үйл ажиллагаа				127 000₮	Хүүхэд-гэр бүл хөгжлийн өргөөг идэвхтэй, үр дүнтэй ажиллуулах төлөвлөлтөд санал, хүсэлт авна.
Банкны шимтгэл				20 000₮	
<b>Бүгд</b>				<b>2666\$*2000=5 332 000</b>	

#### **Хэсэг VI** Төслийн тогтвортой байдал

Энэхүү эцэг эхийг чадавчжуулах, СЭЭБХ-г бэрхжүүлэх төслийг хэрэгжүүлснээр манай сумын СЭЭБХ нь илүү байгууллагын түвшинд бэхжих, эцэг эхийн оролцоо нэмэгдэнэ. Мөн гэрээр айлчлах хөтөлбөрийг хэрэгжүүлснээр эцэг эхчүүд хүүхдийнхээ сурлагын амжилтыг дээшлүүлэхэд анхаарч, сургуулийн удирдлага, СЭЭБХ-той хамтран ажилладаг болно. Ном хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр эцэг эхчүүдийн унших чадвар сайжирч, хүүхдийнхээ эх хэлний хичээлийн даалгаварыг хийлгэх чадвартай болно. Мөн эцэг эхчүүд хоорондоо харилцан ярилцах орон зайтай болох юм.

Төслийн саналыг дэмжсэн гишүүдийн гарын үсэг, нэр:

СЭЭБХ-ны Зохицуулагч:		Нэр: Т.Мөнгөн Гарын үсэг: <i>Т.Мөнгөн</i>
Төслийг боловсруулсан	Эцэг эх \ Нэр: М.Мэндбаяр <i>М.Мэндбаяр</i>	Огноо 2018 он 12 сарын 12 өдөр 
	Эцэг эх \ Нэр: А.Алтанчимэг <i>А.Алтанчимэг</i>	
	Эцэг эх \ Нэр: Б.Нарангарав <i>Б.Нарангарав</i>	
	Багш \ Нэр: Г.Цэцэгбаяр <i>Г.Цэцэгбаяр</i>	
	Багш \ Нэр: О.Энхчимэг <i>О.Энхчимэг</i>	
	Багш \ Нэр: П.Баярмагнай <i>П.Баярмагнай</i>	